

# ДОЛООДУГААР БҮЛЭГ

## ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ




## ӨРХИЙН ТОО, БҮТЭЦ

Өрхийг “Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо садан төрлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно. Өрх гэдэг ойлголт нь гэр бүл гэдэг ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно” гэж тодорхойлдог. Өрхийн талаарх энэ тодорхойлолт нь өмнөх тооллогууд болоод олон улсад ашигладаг нэгдмэл ойлголт юм.

Хүн амыг үндсэнд нь өрхөд, өрх үүсгээгүй нэгжид тоологдсон гэж 2 ангилдаг. Өрх үүсгээгүй нэгж гэж “Нийтээрээ буюу хэсэг бүлгээрээ амьдарч байгаа хоорондоо гэр бүл ураг төрөл, хамаатан садны холбоогүй хүмүүсийг” хэлнэ. Өрх үүсгээгүй нэгжийн хүмүүс ихэвчлэн цэрэг, хоригдол, оюутан сурагчид болон ажиллагчдын нийтийн байр, эмнэлэг, сувилал, зочид буудлын нэг өрөөнд хамт амьдарч байгаа болон орон сууцны нэг өрөө буюу бүхэлд нь хөлслөн сууж байгаа мөн байшингийн дээвэр хонгил, орц, дулааны шугам сүлжээний сувагт хамт амьдардаг, ураг төрөл, хамаатан садны холбоогүй хүмүүс юм.

ЗУРАГ 7.1 ӨРХ, ӨРХӨД ХАМААРАЛГҮЙ ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, 2020 ОН



Хүн ам, орон сууны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 14 212 өрхөд суурин хүн амын 98.5 хувь буюу 45 994 хүн, өрх үүсгээгүй нэгжид 1.5 хувь буюу 704 хүн тус тус тоологдов (Зураг 7.1).

ХҮСНЭГТ 7.1. ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

	2010		2020		2020/ 2010%
	Хүн	дүнд эзлэх хувь	Хүн	дүнд эзлэх хувь	
<b>БҮГД</b>	<b>38 543</b>	<b>100.0</b>	<b>46 698</b>	<b>100.0</b>	<b>121.2</b>
Өрхөд	37 319	96.8	45 994	98.5	123.2
Өрх үүсгээгүй нэгжид	1 224	3.2	704	1.5	57.5

Өрхөд тоологдсон хүний тоо өмнөх тооллогын үеийнхээс 8675 хүнээр буюу 23.2 хувиар өсөж, өрх үүсгээгүй нэгжид тоологдсон хүний тоо өмнөх тооллогын үеийнхээс 520 хүнээр буюу 42.5 хувиар буурсан байна.

### ХҮСНЭГТ 7.2. ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, СУМДААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Сумд	Өрхийн хамаарал					
	Бүгд	Хувь	Өрхөд тоологдсон хүн ам	Хувь	Өрхөд хамаарахгүй хүн ам	хувь
<b>БҮГД</b>	<b>46 698</b>	<b>100.0</b>	<b>45 994</b>	<b>98.5</b>	<b>704</b>	<b>1.5</b>
Сайнцагаан	15 764	100.0	15 601	99.0	163	1.0
Адаацаг	2 832	100.0	2 787	98.4	45	1.6
Баянжаргалан	1 301	100.0	1 294	99.5	7	0.5
Говь-Угтаал	1 540	100.0	1 504	97.7	36	2.4
Гурвансайхан	2 133	100.0	2 081	97.6	52	2.5
Дэлгэрхангай	2 301	100.0	2 258	98.1	43	1.9
Дэлгэрцогт	1 639	100.0	1 630	99.5	9	0.6
Дэрэн	2 142	100.0	2 116	98.8	26	1.2
Луус	1 883	100.0	1 849	98.2	34	1.8
Өлзийт	2 373	100.0	2 251	94.9	122	5.4
Өндөршил	1 406	100.0	1 376	97.9	30	2.2
Сайхан-Овоо	2 131	100.0	2 104	98.7	27	1.3
Хулд	2 383	100.0	2 363	99.2	20	0.8
Цагаандэлгэр	1 038	100.0	1 031	99.3	7	0.7
Эрдэнэдалай	5 832	100.0	5 749	98.6	83	1.4

Өрх үүсгээгүй нэгжид тоологдсон хүн амын аймгийн дундаж 1.5 байна. Өлзийт, Гурвансайхан, Говь-Угтаал, Өндөршил, Дэлгэрхангай, Луус, Адаацаг сумдад аймгийн дунджаас 0.1-3.9 пунктээр өндөр байна.

### ХҮСНЭГТ 7.3. СУМДЫН ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ӨСӨЛТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Сумд	2010		2020		2020/2010 %
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	
<b>БҮГД</b>	<b>10 895</b>	<b>100.0</b>	<b>14 212</b>	<b>100.0</b>	<b>130.4</b>
Сайнцагаан	3 816	35.0	4 737	33.3	124.1
Адаацаг	619	5.7	799	5.6	129.1
Баянжаргалан	307	2.8	451	3.2	146.9
Говь-Угтаал	402	3.7	498	3.5	123.9
Гурвансайхан	503	4.6	662	4.7	131.6

Дэлгэрхангай	550	5.1	674	4.7	122.5
Дэлгэрцогт	359	3.3	563	4.0	156.8
Дэрэн	386	3.5	611	4.3	158.3
Луус	379	3.5	564	4.0	148.8
Өлзийт	504	4.6	749	5.3	148.6
Өндөршил	416	3.8	467	3.3	112.3
Сайхан-Овоо	493	4.5	660	4.6	133.9
Хулд	457	4.2	718	5.1	157.1
Цагаандэлгэр	239	2.2	396	2.8	165.7
Эрдэнэдалай	1 465	13.5	1 663	11.7	113.5

Өрх үүсгээгүй нэгжид тоологдсон хүн амын аймгийн дундаж 1.5 байна. Өлзийт, Гурвансайхан, Говь-Угтаал, Өндөршил, Дэлгэрхангай, Луус, Адаацаг сумдад аймгийн дунджаас 0.1-3.6 пунктээр өндөр байна.

#### ХҮСНЭГТ 7.4. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

	2010		2020		2020 2010 %
	Өрх	ДҮНД ЭЗЛЭХ хувь	Өрх	ДҮНД ЭЗЛЭХ хувь	
<b>БҮГД</b>	<b>10 895</b>	<b>100.0</b>	<b>14 212</b>	<b>100.0</b>	<b>130.4</b>
<b>Хот</b>	3 816	35.0	3 726	26.2	97.6
<b>Хөдөө</b>	7 079	65.0	10 486	73.8	148.1

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор 14212 өрх тоологдсон байна. Энэ нь өмнөх тооллогын дүнгээс 3317 буюу 30.4 хувиар (жилд дунджаар 3.0 хувиар) өссөн байна.


Үүний дотор хотын өрх 3726 буюу 2.4 хувиар (жилд дунджаар 0.2 хувиар) буурч, хөдөөгийн өрх 10486 буюу 48.1 хувиар (жилд дунджаар 4.8 хувиар) өсжээ. Хөдөөгийн өрх өссөн нь сүүлийн жилүүдэд төрөөс малчдыг дэмжих, тэтгэвэр халамжид хамруулах бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.

2020 оны тооллогоор тоологдсон 14 212 өрхийн 26.2 хувь нь хотод, 73.8 хувь нь хөдөөд амьдарч байна. Хөдөөд амьдарч байгаа өрхийн хувь өмнөх тооллоготой харьцуулахад 8.8 пунктээр нэмэгдсэн байна.

#### ӨРХИЙН ХЭЛБЭР

Өрхийн хэлбэрийг НҮБ-ын аргачлалын дагуу тодорхойлдог ба ингэхдээ тухайн өрхөд тоологдсон өрхийн гишүүдийн өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг харгалздаг. Энэ нь улс орны нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн дунд болон урт хугацааны бодлого боловсруулах үндсэн мэдээлэл болдог. Өрхийг өмнөх тооллогуудын мөн адил 4 хэлбэрт ангилсан.

ЗУРАГ 7.2 ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Өрхийн бүтцийн хувьд авч үзвэл 63.4 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 16.2 хувь нь нийлмэл ам бүлтэй өрх, 19.8 хувь нь ганц бие өрх, 0.2 хувь нь холимог, ам бүлтэй өрх байна. Өмнөх тооллогын дүнгээс ам бүлээрээ байгаа өрх 1 839 буюу 25.7 хувиар, нийлмэл ам бүлтэй өрх 96 буюу 4.4 хувиар, ганц бие өрх 1 584 буюу 2.2 дахин тус тус өссөн байна. (Зураг 7.2).

Өөрөөр хэлбэл, 10 өрх тутмын 6 нь ам бүлээрээ буюу эхнэр, нөхөр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх байна. Мөн ганц бие өрхөөрөө амьдарч байгаа хүн 20 орчим хувийг эзэлж байгаа нь хөдөөгийн малчдын дийлэнх эрэгтэйчүүд малаа маллан ганцаараа амьдардагтай холбоотой гэж үзэж байна. Нийлмэл ам бүлтэй, өөрөөр хэлбэл эцэг эх, ах дүүс, садан төрлөөрөө амьдарч байгаа бүтэцтэй өрх ч мөн нилээдгүй хувийг эзэлж байгаа нь үр хүүхэд, хамаатан садантайгаа хамт амьдрах манай уламжлалт заншилтай уялдаатай гэж үзэж болно.

ХҮСНЭГТ 7.5. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Өрхийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	дүнд эзлэх хувь
<b>2010</b>						
<b>БҮГД</b>	<b>10 895</b>	<b>100.0</b>	<b>3 816</b>	<b>100.0</b>	<b>7 079</b>	<b>100.0</b>
Ганц бие	1 276	11.7	407	10.7	869	12.3
Ам бүлээрээ	7 155	65.7	2 350	61.6	4 805	67.9
Нийлмэл	2 198	20.2	945	24.8	1 253	17.7
Холимог	266	2.4	114	3	152	2.1
<b>2020</b>						
<b>БҮГД</b>	<b>14 212</b>	<b>100.0</b>	<b>3 726</b>	<b>100.0</b>	<b>10 486</b>	<b>100.0</b>
Ганц бие	2 860	20.1	626	16.8	2 234	21.3
Ам бүлээрээ	8 994	63.3	2 329	62.5	6 665	63.6
Нийлмэл	2 294	16.1	745	20.0	1 549	14.8
Холимог	64	0.5	26	0.7	38	0.4

Ганц бие өрхийн тоо хотод 626, хөдөө 2234 байгаа нь хөдөөд 3.6 дахин их бөгөөд өмнөх тооллогын дүнгээс 9 пунктээр өссөн, нийлмэл өрх хөдөөд дийлэнх нь буюу 67.5 хувь нь амьдарч байна. Энэ нь төв, суурин газраас хөдөөрүү шилжих хөдөлгөөн нэмэгдэж ганцаараа өрх үүсгэн

мал аж ахуй эрхэлж байгаатай холбон тайлбарлаж болох юм. Мөн холимог өрхийн тоо өмнөх тооллогын дүнгээс 4 дахин буурсан нь ураг төрлийн хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдрах нь багасч байгааг харуулж байна.

#### ХҮСНЭГТ 7.6. ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Хот		Хөдөө	
	өрх	Хувь	өрх	Хувь	өрх	хувь
<b>2010</b>						
<b>БҮГД</b>	<b>10 895</b>	<b>100.0</b>	<b>3 816</b>	<b>100.0</b>	<b>7 079</b>	<b>100.0</b>
1-2	3 234	29.7	1 112	29.1	2 122	30.0
3-4	5 153	47.3	1 856	48.6	3 297	46.6
5-6	2 196	20.2	704	18.4	1 492	21.1
7+	312	2.9	144	3.8	168	2.4
<b>2020</b>						
<b>Бүгд</b>	<b>14 212</b>	<b>100.0</b>	<b>3 726</b>	<b>100.0</b>	<b>10 486</b>	<b>100.0</b>
1-2	5 504	38.7	1 345	36.1	4 159	39.7
3-4	5 159	36.3	1 461	39.2	3 698	35.3
5-6	3 058	21.5	766	20.6	2 292	21.9
7+	491	3.5	154	4.1	337	3.2

Өрхийн ам бүлийн тоо хот, хөдөөгөөр ялгаатай байгаа боловч аймгийн хэмжээний өрхийн ам бүлийн дундаж хэмжээ болох 3-4 ам бүлтэй өрхийн эзлэх хувь хотод 28.3 хувь, хөдөөд 71.6 хувьтай байна. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал: 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 1-2 ам бүлтэй өрх хотод 1345 буюу 20.9 хувиар, хөдөөд 4159 буюу 1.9 дахин тус тус өссөн байна. 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн тоо хөдөөд хотоос 2.2 дахин их байна.

#### ХҮСНЭГТ 7.7. ӨРХИЙН ТОО, СУМД, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2010, 2020 ОН

Сумд	Бүгд	Ам бүлийн тоогоор				Өрхийн ам бүлийн дундаж тоо	
		1-2	3-4	5-6	7, түүнээс дээш	2010	2020
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>38.7</b>	<b>36.3</b>	<b>21.5</b>	<b>3.5</b>	<b>3.4</b>	<b>3.3</b>
Сайнцагаан	100.0	36.2	39.2	20.5	4.1	3.1	3.0
Адаацаг	100.0	34.3	35.8	25.7	4.3	3.7	2.8
Баянжаргалан	100.0	48.8	31.9	17.3	2.0	3.1	3.4
Говь-Угтаал	100.0	44.2	34.3	18.9	2.6	2.7	3.2
Гурвансайхан	100.0	40.0	36.7	21.3	2.0	3.5	1
Дэлгэрхангай	100.0	35.2	37.1	24.8	3.0	3.3	2.9
Дэлгэрцогт	100.0	46.7	34.3	16.2	2.8	3.2	3.4
Дэрэн	100.0	34.9	35.7	24.7	4.7	3.4	2.8
Луус	100.0	37.4	37.6	21.6	3.4	3.5	2.9
Өлзийт	100.0	43.9	34.2	20.8	1.1	3.5	3.1
Өндөршил	100.0	42.6	39.8	16.9	0.6	3.4	3.3

Сайхан-Овоо	100.0	41.4	33.2	22.3	3.2	3.8	3.1
Хулд	100.0	38.9	34.3	22.1	4.7	3.4	3.0
Цагаандэлгэр	100.0	56.1	25.3	17.2	1.5	3.5	3.7
Эрдэнэдалай	100.0	35.2	34.7	25.7	4.4	3.7	2.8

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор өрхийн ам бүлийн дундаж тоо 3.3 гарсан нь өмнөх тооллоготой харьцуулахад 0.1 пунктээр буурсан байна. Энэ нь улсын дундажаас 0.3 пунктээр бага байгаа юм. Өрхийн ам бүлийн дундаж тоо Говь-Угтаал суманд 0.3 пунктээр өссөн, бусад сумдад 0.1-1 пунктээр буурсан байна. (Хүснэгт 7.6) Өрхийн ам бүлийн дундаж тоо Цагаандэлгэр, Баянжаргалан, Дэлгэрцогт сумдад хамгийн өндөр бөгөөд аймгийн дунджаас бараг нэг хүнээр илүү байна.

#### ХҮСНЭГТ 7.8. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН

Өрх	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь
<b>2010</b>						
Бүгд	10 895	100.0	3 816	100.0	7 079	100.0
Эрэгтэй тэргүүлэгчтэй	8 929	82.0	2 995	78.5	5 934	83.8
Эмэгтэй тэргүүлэгчтэй	1 966	18.0	821	21.5	1 145	16.2
<b>2020</b>						
Бүгд	14 212	100.0	3 726	100.0	10 486	100.0
Эрэгтэй тэргүүлэгчтэй	10 486	73.8	2 248	60.3	8 349	79.6
Эмэгтэй тэргүүлэгчтэй	3 726	26.2	1 478	39.7	2 137	20.4

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор нийт өрхийн 73.8 хувь нь эрэгтэй тэргүүлэгчтэй өрх, 26.2 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна. Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 8.2 пунктээр, хотод 18.2 пунктээр, хөдөөд 4.2 пунктээр тус тус нэмэгджээ.

#### ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн амын төрөлт, өсөлтөд шууд нөлөөлдөг хүчин зүйл бол гэр бүлийн байдал юм. Гэрлэх нь үндэсний соёл, уламжлалтай нягт холбоотой явагддаг нийгмийн үзэгдэл тул түүний үндсэн төрх тооллого хоорондын жилүүдэд төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

ХҮСНЭГТ 7.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Гэр бүлийн байдал	2000		2010		2020	
	ХҮН	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ	ХҮН	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ	ХҮН	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ
<b>БҮГД</b>	<b>27 894</b>	<b>100.0</b>	<b>26 427</b>	<b>100.0</b>	<b>32 539</b>	<b>100.0</b>
<b>Огт гэр бүл болоогүй</b>	6 128	22.0	6 861	26.0	10 024	30.8
<b>Гэр бүлтэй<sup>1</sup></b>	18 954	68.0	17 458	66.2	19 717	60.6
<b>Цуцалсан<sup>2</sup></b>	737	2.6	666	2.5	957	2.9
<b>Бэлэвсэн</b>	2 075	7.4	1 352	5.3	1 847	5.7

<sup>1</sup> батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

<sup>2</sup> тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Гэрлэлтээ цуцалсан болон тусгаарласан хүний эзлэх хувь өмнөх тооллогын дүнгээс 0.6 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 7.10. АРВАН ТАВ ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010 ОН, 2020 ОН

Гэр бүлийн байдал	Бүгд		Эрэгтэй тэргүүлэгчтэй		Эмэгтэй тэргүүлэгчтэй	
	ХҮН	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ	ХҮН	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ	ХҮН	ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ
<b>2010</b>						
<b>БҮГД</b>	<b>26 427</b>	<b>100.0</b>	<b>13 358</b>	<b>100.0</b>	<b>13 069</b>	<b>100.0</b>
<b>Огт гэр бүл болоогүй</b>	6 861	26.0	4 029	30.2	2 832	21.7
<b>Гэр бүлтэй<sup>2</sup></b>	17 548	66.4	8 721	65.3	8 827	67.5
<b>Цуцалсан<sup>3</sup></b>	666	2.5	312	2.3	354	2.7
<b>Бэлэвсэн</b>	1 352	5.1	296	2.2	1 056	8.1
<b>2020</b>						
<b>БҮГД</b>	<b>32 539</b>	<b>100.0</b>	<b>16 161</b>	<b>100.0</b>	<b>16 378</b>	<b>100.0</b>
<b>Огт гэр бүл болоогүй</b>	10 024	30.8	5 689	35.2	4 335	26.5
<b>Гэр бүлтэй<sup>2</sup></b>	19 717	60.6	9 724	60.2	9 993	61.0
<b>Цуцалсан<sup>3</sup></b>	957	2.9	449	2.8	508	3.1
<b>Бэлэвсэн</b>	1 841	5.7	299	1.8	1 542	9.4

<sup>2</sup> батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

<sup>3</sup> тусгаарласан хүмүүсийг оруулсан.

15, түүнээс дээш настай хүн амыг гэрлэлтийн байдлаар харвал 30.8 хувь нь огт гэрлээгүй, 60.6 хувь нь батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй, 2.9 хувь нь гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан, 5.7 хувь нь бэлэвсэн байна. Өмнөх тооллогын дүнгээс огт гэрлээгүй хүмүүс 3 163 буюу 46.1 хувиар, батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүс 2 259 буюу 12.9 хувиар, бэлэвсэн хүмүүсийн хувьд 489 буюу 36.6 хувиар, цуцалсан болон тусгаарласан хүмүүсийн хувьд 291 буюу 43.6 хувиар тус тус өссөн байна. Анхны гэрлэлтийн дундаж нас гэсэн үзүүлэлт нь эрэгтэй, эмэгтэйчүүд анх хэдэн насандаа гэр бүл болж байгааг илэрхийлдэг.



15-24	24.0	62.6	3.3	0.9	0.3	22.1	69.1	6.2	1.8	0.2
25-34	22.3	22.9	23.2	9.4	1.3	20.6	16.1	25.3	22.2	2.1
35-44	20.4	8.2	27.4	34.2	3.0	19.7	5.8	27.6	25.0	6.4
45-54	16.2	3.9	22.8	31.6	11.7	16.0	3.8	21.2	26.2	13.2
55-64	10.8	1.7	15.5	18.3	21.7	12.6	3.6	13.8	18.9	27.9
65+	6.3	0.7	7.8	5.6	62.0	9.0	1.6	5.9	5.9	50.2

<sup>1</sup> батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

<sup>2</sup> тусгаарласан хүмүүсийг оруулсан.


Гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан хүн амд 45-64 насныхны эзлэх хувь өмнөх тооллоготой харьцуулахад аль ч хүйсийн хувьд нэмэгдсэн, ялангуяа 55-64 насны бүлэгт хүйс тус бүрд 10 орчим пунктээр нэмэгдсэн байна.

### ХҮСНЭГТ 7.12. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Эрэгтэй					Эмэгтэй				
	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй <sup>1</sup>	Цуцалсан <sup>2</sup>	Бэлэвсэн	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй <sup>1</sup>	Цуцалсан <sup>2</sup>	Бэлэвсэн
<b>2010</b>										
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>30.2</b>	<b>65.3</b>	<b>2.3</b>	<b>2.2</b>	<b>100.0</b>	<b>21.7</b>	<b>67.5</b>	<b>2.7</b>	<b>8.1</b>
15-24	100.0	81.6	17.9	0.5	-	100.0	65.6	33.7	0.5	0.2
25-34	100.0	23.7	73.8	2.2	0.2	100.0	13.6	83.1	2.8	0.5
35-44	100.0	9.8	85.9	3.6	0.6	100.0	7.7	85.3	4.0	3.0
45-54	100.0	5.5	89.1	3.4	2.0	100.0	7.2	79.2	4.3	9.3
55-64	100.0	3.7	88.3	3.0	5.0	100.0	4.9	71.7	3.4	19.9
65+	100.0	1.2	7.5	7.7	62.8	100.0	6.4	42.3	1.6	49.7
<b>2020</b>										
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>35.2</b>	<b>60.2</b>	<b>2.8</b>	<b>1.9</b>	<b>100.0</b>	<b>26.5</b>	<b>61.0</b>	<b>3.1</b>	<b>9.4</b>
15-24	100.0	91.7	8.2	0.1	-	100.0	82.6	20.6	1.5	33.3
25-34	100.0	36.2	62.5	1.2	0.1	100.0	20.7	75.0	3.4	1.0
35-44	100.0	14.2	80.8	4.7	0.3	100.0	7.8	85.3	3.9	3.0
45-54	100.0	8.4	84.8	5.4	1.3	100.0	6.3	80.9	5.1	7.8
55-64	100.0	5.4	86.1	4.7	3.7	100.0	7.5	66.9	4.7	20.9
65+	100.0	3.9	75.4	2.5	18.3	100.0	4.7	40.5	2.0	52.8

Бэлэвсэн эмэгтэйчүүдийн хувь аль ч насанд эрэгтэйчүүдийнхээс мэдэгдэхүйц их байна. Ялангуяа 65, түүнээс дээш насанд бэлэвсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 34.5 пунктээр илүү байгаа бөгөөд тухайн насны бүлэгт эрэгтэйчүүдийн нас баралт өндөр байгаатай холбоотой.


ЗУРАГ 7.4. ГЭРЛЭЛТЭЭ ЦУЦАЛСАН ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР 2010, 2020 ОН



Гэрлэлтээ цуцлуулсан хүний тоо 2010 онд 35-44 насанд өндөр байсан бол 2020 оны тооллогын дүнгээс 45-54 насанд гэр бүл цуцлалт илүү нэмэгдсэн байна.

# НАЙМДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ



## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хууль, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”, Ази Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги 2012-2022 зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний бүрэн оролцоог хангасан, ая тухтай, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх асуудлаарх үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх дэлгэрэнгүй, үнэн бодит тоо мэдээлэл зайлшгүй шаардлагатай байдаг. Иймээс НҮБ-ын тооллогын зарчим зөвлөмжид хөгжлийн бэрхшээлийн асуудлыг үндсэн үзүүлэлтээр оруулахыг зөвлөмж болгосон байдаг.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх тоо мэдээллийг гаргах нь улс орны хөгжлийн бодлого хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын бодлого хөтөлбөрийг боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн өргөн хүрээний хэрэгцээг тодорхойлох, тэдгээрийн оролцоог бүхий л салбарт өсөн нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэхэд нэн ач холбогдолтой.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын онцлогоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо мэдээллийг Хүн ам, өрхийн мэдээллийн сан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Эрүүл мэндийн яамны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сангуудыг уялдуулж гаргасан.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ


Дундговь аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2020 онд 1 858 болж өмнөх тооллогоос 1.2 хувиар буурч, суурин хүн амын 4.0 хувийг эзэлж байна.

### ХҮСНЭГТ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	1 881	100.0	1 858	100.0
0-4	44	2.3	25	1.3
5-9	59	3.1	61	3.3
10-14	85	4.5	72	3.9
15-19	115	6.1	53	2.9
20-24	133	7.1	69	3.7
25-29	169	9.0	119	6.4
30-34	183	9.7	169	9.1
35-39	183	9.7	174	9.4
40-44	217	11.5	209	11.2
45-49	212	11.3	239	12.9
50-54	167	8.9	239	12.9
55-59	93	5.0	223	12.0
60-64	43	2.3	115	6.2
65-69	36	1.9	39	2.1
70+	142	7.6	52	2.8

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 4.6 хувийг 0-9 насны хүүхэд, 6.8 хувийг 10-19 нас буюу өсвөр үеийнхэн, 10.1 хувийг 20-29 насныхан, 18.5 хувийг 30-39 насныхан, 49 хувийг 40-59 насныхан, 11.1 хувийг 60-аас дээш насныхан эзэлж байгаа бөгөөд өмнөх тооллоготой харьцуулахад 0-9 насныхан 0.8 пункт, 10-19 насныхан 3.8 пункт, 20-29 насныхан 6 пункт, 30-39 насныхан 0.9 пункт, 60-аас дээш насныхан 0.7 пунктээр тус тус өссөн бол 40-49 насныхан 1.3 пункт, 50-59 насныхан 11 пункт, 60-69 насныхан 4.1 пунктээр тус тус буурчээ.

ЗУРАГ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР 2010, 2020 ОН



2020 оны тооллогын дүнгээр нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 1 040 буюу 56.0 хувийг эрэгтэйчүүд, 818 буюу 44.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

ХҮСНЭГТ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, СУМДААР ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Сумд	2010		2020		2010 / 2020%
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	
<b>БҮГД</b>	<b>1 881</b>	<b>100.0</b>	<b>1 858</b>	<b>100.0</b>	<b>98.8</b>
Сайнцагаан	640	34.0	689	37.1	107.7
Адаацаг	95	5.1	114	6.1	120.0
Баянжаргалан	55	2.9	26	1.4	47.3
Говь-Угтаал	90	4.8	84	4.5	93.3
Гурвансайхан	93	4.9	85	4.6	91.4
Дэлгэрхангай	99	5.3	114	6.1	115.2
Дэлгэрцогт	90	4.8	84	4.5	93.3
Дэрэн	74	3.9	63	3.4	85.1


Луус	72	3.8	87	4.7	120.8
Өлзийт	87	4.6	85	4.6	97.7
Өндөршил	41	2.2	45	2.4	109.8
Сайхан-Овоо	52	2.8	59	3.2	113.5
Хулд	69	3.7	74	4.0	107.2
Цагаандэлгэр	30	1.6	23	1.2	76.7
Эрдэнэдалай	294	15.6	226	12.2	76.9

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоогоор Сайнцагаан, Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрхангай сумдууд хамгийн олон, Цагаандэлгэр, Баянжаргалан сумд хамгийн цөөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2010 онтой харьцуулахад Адаацаг, Дэлгэрхангай, Луус, Сайхан-Овоо сумдууд хамгийн өндөр өсөлттэй байгаа бол Эрдэнэдалай, Баянжаргалан, Цагаандэлгэр сумдууд хамгийн өндөр бууралттай байна.

Сайнцагаан суманд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 37.1 хувь (0.7 мянга) нь оршин сууж байгаа бөгөөд өсөлтийн түвшин нь 2010 оныхоос 3.1 пунктээр нэмэгдсэн байна.

ЗУРАГ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, СУМ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР 2010, 2020 ОН




Тухайн сумын нийт хүн амд эзэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийг өмнөх тооллоготой харьцуулахад Сайнцагаан, Адаацаг, Луус, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Хулд сумдад 0.4-3.1 пунктээр буюу хамгийн ихээр өссөн бол Баянжаргалан, Эрдэнэдалай сумдад 1.5-3.4 пунктээр буюу хамгийн ихээр буурчээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 29.2 хувь буюу 543 нь хотод, 70.8 хувь буюу 1315 нь хөдөөд амьдарч байна.

Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Адаацаг суманд хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү олноороо оршин сууж байна. Хотод амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өмнөх тооллоготой харьцуулахад 15.1 хувиар буурч, хөдөө оршин сууж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд Дэлгэрхангай, Адаацаг, Луус, Сайхан-Овоо, Хулд сумдад өсөж, бусад сумдад буурсан үзүүлэлттэй байна.


**ЗУРАГ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН**



Тооллогоор нийт 1858 хөгжлийн бэрхшээлтэй иргэд тоологдсоны 945 (50.9 хувь) нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байгаа ба өмнөх тооллогоос 6.4 пунктээр өсөж, олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 913 (49.1 хувь) байгаа нь өмнөх тооллогоос 6.4 пунктээр буурсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 46.8 хувь (487) нь төрөлхийн, 53.2 хувь (553) нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 56.0 хувь (458) нь төрөлхийн, 44.0 хувь (360) нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. (Зураг 8.3) Дээрхээс харахад 2020 онд хөгжлийн бэрхшээлтэй 10 эмэгтэй тутмын 4 нь олдмол байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 2 хүнээр буурсан, эрэгтэйчүүдийн хувьд 5 буюу ижил түвшинд байна.

## ЗУРАГ 8.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН



Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл 24.7 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй, 24.3 хувь нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 29.2 хувь нь бусад (хавсарсан болон бусад хөгжлийн бэрхшээлийг энд оруулав) төрлийн бэрхшээлтэй хүн ам байгаа нь хамгийн өндөр байна. Харин харааны бэрхшээлтэй хүн ам 11.4 хувь ба ярианы бэрхшээлтэй хүн ам 3.1 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага байна.

Уг үзүүлэлтийг өмнөх тооллогын дүнтэй харьцуулбал хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам 2.7 пунктээр, харааны бэрхшээлтэй хүн ам 4.6 пунктээр, сонсголын бэрхшээлтэй хүн ам 2.2 пунктээр, сэтгэцийн бэрхшээлтэй хүн ам 3.0 пунктээр тус тус буурсан бол бусад төрлийн бэрхшээлтэй хүн ам 12.7 пунктээр өссөн байна.

### ҮЙЛДЛИЙН ЧАДВАР

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор НҮБ-ын Вашингтон бүлгээс боловсруулсан үйлдлийн чадварыг тодорхойлох богино багц асуултуудыг асуусан. Богино багц асуулга нь харах, сонсох, алхах, өөртөө анхаарал тавих, харилцах, ой тогтоолт /санах/ гэсэн 6 багц үйл ажиллагааны хувьд хүндрэлийг тодорхойлдог.


Үйлдлийн хүндрэлийг Вашингтон бүлгийн богино багц асуулгын зөвлөмжийн дагуу 18, түүнээс дээш настай хүн амын хувьд тооцдог. Ингэхдээ дээрх 6 үйлдлийн чадвараас дор хаяж нэгд нь “маш их хүндрэлтэй” эсвэл “огт чадахгүй” гэж хариулсан тохиолдлыг үйлдлийн чадварын хүндрэлтэй гэж үздэг. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын 9.7 хувь нь 18-34 насны залуучууд байгаа бол 40.9 хувь нь 35-64 насны, 49.4 хувь нь 65, түүнээс дээш насны хүн ам байна. Эдгээрийн 33.7 хувь нь алхах, 17.5 хувь нь харааны бэрхшээлтэй байгаа бол хамгийн бага (10.0 хувь) нь харилцах үйлдлийн хүндрэлтэй хүмүүс байна.

### ХҮСНЭГТ 8.3. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Хүндрэлийн хэлбэр					
		Харааны	Сонсголын	Алхах	Ой тогтоолт /санах/	Өөртөө анхаарал тавих	Харилцах
<b>Насны бүлгийн дүнд эзлэх хувиар</b>							
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	17.5	11.1	33.7	16.2	11.4	10.0
<b>18-19</b>	100.0	-	-	-	-	-	-
<b>20-24</b>	100.0	25.0	12.5	25.0	25.0	-	12.5
<b>25-29</b>	100.0	-	16.7	33.3	25.0	8.3	16.7
<b>30-34</b>	100.0	26.7	6.7	13.3	20.0	13.3	20.0
<b>35-39</b>	100.0	22.2	-	44.4	27.8	-	5.6
<b>40-44</b>	100.0	21.7	13.0	34.8	13.0	4.3	13.0
<b>45-49</b>	100.0	15.0	10.0	30.0	20.0	10.0	15.0
<b>50-54</b>	100.0	47.4	-	26.3	15.8	5.3	5.3
<b>55-59</b>	100.0	12.9	12.9	29.0	19.4	9.7	16.1
<b>60-64</b>	100.0	19.4	5.6	47.2	19.4	5.6	2.8
<b>65-69</b>	100.0	13.8	10.3	41.4	13.8	13.8	6.9
<b>70+</b>	100.0	14.2	14.9	32.4	12.2	16.9	9.5
<b>Хүндрэлийн хэлбэрийн дүнд эзлэх хувиар</b>							
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>18-19</b>	-	-	-	-	-	-	-
<b>20-24</b>	2.2	3.2	2.5	1.7	3.4	-	2.8
<b>25-29</b>	3.3	-	5.0	3.3	5.2	2.4	5.6
<b>30-34</b>	4.2	6.3	2.5	1.7	5.2	4.9	8.3
<b>35-39</b>	5.0	6.3	-	6.6	8.6	-	2.8
<b>40-44</b>	6.4	7.9	7.5	6.6	5.2	2.4	8.3
<b>45-49</b>	5.6	4.8	5.0	5.0	6.9	4.9	8.3
<b>50-54</b>	5.3	14.4	-	4.1	5.2	2.4	2.8
<b>55-59</b>	8.6	6.3	10.0	7.4	10.3	7.3	13.9
<b>60-64</b>	10.0	11.1	5.0	14.0	12.1	4.9	2.8
<b>65-69</b>	8.1	6.3	7.5	9.9	6.9	9.8	5.6
<b>70+</b>	41.3	33.4	55.0	39.7	31.0	61.0	38.8

18-34 насныхны хувьд хараа, харилцах, ой тогтоолт /санах үйлдлийн хүндрэл, 35 ба түүнээс насныхны хувьд хараа болон алхах үйлдлийн хүндрэл хамгийн их байна. Тухайн үйлдлийн чадварын хүндрэлийг насны ангиллаар авч үзвэл 45, түүнээс дээш насны хүн амын хүндрэл бусад насны хүн амынхнаас өндөр байна.

**ЗУРАГ 8.6. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ОГТ ХҮНДРЭЛГҮЙ ХҮМҮҮСИЙН СУУРИН ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН**



Дээрх зургаас харахад 55, түүнээс дууш насны хүн амын үйлдлийн чадварын хүндрэл нас ахихын хэрээр их болж байна.

Хүндрэлгүй хүн амын нийт суурин хүн амд эзлэх хувийн жин 35-аас дээш бүх насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс өндөр байна. Энэ нь эмэгтэйчүүд илүү хянамгай, эрүүл мэнддээ анхаардгаас шалтгаалдаг байна.

**ХҮСНЭГТ 8.4. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, СУМДААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН**

Насны бүлэг	Бүгд	Хүндрэлийн хэлбэр					
		Харааны	Сонсголын	Алхах	Ой тогтоолт /санах/	Өөртөө анхаарал тавих	Харилцах
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Сайнцагаан	35.0	33.3	50.0	33.0	29.0	29.0	44.0
Адаацаг	7.0	4.8	3.0	7.0	16.0	5.0	6.0
Баянжаргалан	1.0	-	-	2.0	-	-	-
Говь-Угтаал	2.0	-	3.0	4.0	2.0	2.0	-
Гурвансайхан	1.0	-	-	2.0	2.0	2.0	-
Дэлгэрхангай	4.0	4.8	-	4.0	3.0	5.0	3.0
Дэлгэрцогт	3.0	1.6	3.0	5.0	2.0	2.0	-
Дэрэн	14.0	20.6	10.0	9.0	12.0	22.0	19.0
Луус	4.0	4.8	5.0	5.0	3.0	-	-
Өлзийт	1.0	-	-	2.0	2.0	5.0	-



Цалин хөлстэй байнгын ажиллагч	22.2	7.7	19.0	8.3	20.0	0.0	22.2
Цалин хөлстэй түр ажиллагч	3.7	7.7	4.8	8.3	0.0	0.0	3.7
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	-	-	-	-	-	-	-
Цалин хөлстэй дагалдан, дадлагажигч	-	-	-	-	-	-	-
Гүйцэтгэх гэрээлэгч	-	-	-	-	-	-	-
ААНБ-ын ажил олгогч	-	-	-	-	-	-	-
Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	-	-	-	-	-	-	-
Цалин хөлстэй ажилтангүй ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	-	-	-	-	-	-	-
Цалин хөлстэй ажилтангүй, зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч	70.4	76.9	61.9	75.0	80.0	100.0	70.4
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	3.7	7.7	14.3	8.3	0.0	0.0	3.7

Тооллогоор нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн 42.9 хувь нь ажилтай гэж бүртгэгдсэн, хөдөлмөр эрхэлдэг ба эдгээр хүмүүсийг ажил эрхлэлтийн байдлаар нь үзэхэд 70.4 хувь нь өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч, 22.2 хувь нь байнгын ажиллагч, 3.7 хувь нь цалин хөлстэй түр ажиллагч, 3.7 хувь нь хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн байна.

Аль ч хүндрэлийн давхардлаар өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч дийлэнх хувийг эзэлж байна. Харин ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч болон ААНБ-ын ажил олгогч, дагалдан, мэргэшиж буй дадлагажигчид маш бага байна. Үүнээс харахад үйлдлийн чадварын хүндрэлийн давхардал нэмэгдэх тусам хүмүүсийн ажиллах боломж нь харьцангуй бага, эсрэгээрээ өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэх болон хувь нэмрээ оруулах үйлчилгээнд оролцох байдал илүү байдаг байна